

БАТЛАВ:
“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН
ЗАХИРГАА, УДИРДЛАГА,
САНХҮҮГИЙН ГАЗРЫН ДАРГА
Д.ҮҮРИЙНТУЯА
2024.01.15

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ
ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨЛӨЛ, ХУВЬ НЭМРИЙГ ТОДОРХОЙЛОХ
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Ерөнхий зүйл

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын нийгэм, эдийн засагт голлох байр суурийг эзэлж, улсын төсвийн бүрдүүлэлтэд чухал хувь нэмэр оруулсаар ирсэн. Зөвхөн 2022 онд Эрдэнэт үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь нь 6%, улсын төсөвт оруулж буй хувь нэмэр 11 орчим хувьтай байна.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын тархалтын улмаас эдийн засгийн нөхцөл хүндэрсэн үед “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь эдийн засагт оруулах хувь нэмрийг зөвхөн татвар, төлбөр, хураамжийг бүрэн төлөх үүргээ биелүүлэхээр хязгаарлалгүйгээр цар тахлын улмаас санхүүгийн хүнд нөхцөлд байгаа бүх айл өрх, зарим бизнесийн байгууллагын цахилгаан, дулаан, уур ус, хог хаягдлын төлбөрийг 2020 оны 12 сарын 01-ний өдрөөс эхлэн 18 сарын хугацаанд бүрэн хариуцсан. Үүнээс гадна ажилтнуудын нийгмийн халамж болон улс, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй нийгмийн хариуцлагын төслийн хүрээнд зарцуулж буй санхүүжилт жил бүр өссөөр ирсэн.

2024 оноос “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу хүчин чадал нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын ажлууд эрчимжиж, Үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалт эхэлж, Эрдэнэт үйлдвэрийг түшиглэсэн Аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх шинэ үеийн босгон дээр ирээд байна. Энэхүү шинэ үеийн босгон дээр Монгол Улсын эдийн засаг болон нийгэмд Эрдэнэт үйлдвэрийн оруулж буй хувь нэмрийг цогцоор нь буюу бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын үр дүнд бүтээж буй нийт үнэ цэнийг Монгол Улсын эдийн засгийн салбар хоорондын тооцоо, шууд, шууд бус, дам нөлөөг оруулан тооцсон суурь судалгааг хийж, цаашид Аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлсний үр дүнд Монгол Улсын ДНБ-ий өсөлтөд хэрхэн нөлөөлөх тооцоог мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай байна. Уг судалгааны ажлыг макро эдийн засаг, үндэсний тооцоо, статистикийн мэдээллийн боловсруулалтаар мэргэшсэн, судалгааны мэргэжлийн багаар гүйцэтгүүлэн, шинжлэх ухаан, онол аргазүйд суурилсан, олон улсад түгээмэл ашигладаг аргачлалаар тооцно.

Судалгааны ажлыг мэргэжлийн, хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлснээр, хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудыг судалгаа, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах боломжтой болох бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн бизнесийн үнэ цэнийг бодитойгоор тооцож, олон улсад нэр хүндийг өсгөх, цаашид Үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтад оролцох стратегийн хөрөнгө оруулагчдыг татахад чухал ач холбогдолтой суурь баримт бичиг болно.

2. Зорилго

- (1) Санхүү, эдийн засгийн онол, аргазүй болон олон улсад ашиглаж буй сүүлийн үеийн тооцооллын аргачлалд тулгуурлан, Монгол Улсын нийгэм, эдийн засагт Эрдэнэт үйлдвэрийн үзүүлэх хувь нэмрийг тодорхойлох загвар боловсруулах,
- (2) Боловсруулсан аргачлал, загварын дагуу Монгол Улсын нийгэм, эдийн засагт Эрдэнэт үйлдвэрийн оруулсан болон оруулж буй хувь нэмрийг судалж, тооцон дүгнэлт гаргах,
- (3) Улс орны нийгэм, эдийн засгийн гэнэтийн тааламжгүй нөхцөл байдлыг даван туулахад Эрдэнэт үйлдвэрийн оруулсан хувь нэмрийг тодорхойлох,
- (4) Монгол Улсын үндэсний болон салбарын бүтээмж, тэдгээрийн өсөлтөд Эрдэнэт үйлдвэрийн оруулсан хувь нэмрийг тодорхойлох,
- (5) Судалгааны үр дүнг англи, монгол хэлээр хэвлүүлж, улс орны эдийн засаг, нийгэмд үйлдвэрийн газрын оруулж буй бодитой хувь нэмрийг дотоодод болон олон улсад таниулах

3. Судалгааны ажлын хүрээнд хийгдэх ажлууд

Даалгавар 1. Санхүү, эдийн засгийн онол, аргазүй болон олон улсад ашиглаж буй тооцооллын аргачлалд тулгуурлан улс орны нийгэм, эдийн засагт компаниудын оруулж буй хувь нэмрийг тодорхойлох судалгаа хийж, судалгааны үр дүнг захиалагч талд танилцуулан зөвшилцсөний үндсэн дээр Эрдэнэт үйлдвэрт тохирох аргачлалыг сонгож, тооцооллын загвар боловсруулах,

Даалгавар 2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас хангах мэдээлэл болон бусад шаардлагатай статистик, тоон мэдээлэлд тулгуурлан, боловсруулсан арга зүй, сонгосон загварчлалын дагуу дараах ерөнхий агуулгын хүрээнд Монгол Улсын нийгэм, эдийн засагт Эрдэнэт үйлдвэрийн үзүүлсэн болон үзүүлж буй шууд, шууд бус болон дам нөлөөг тооцно.

(1) Монгол Улсын ДНБ болон эдийн засгийн өсөлтөд Эрдэнэт үйлдвэрийн үзүүлж буй хувь нэмэр, шууд, шууд бус болон дам нөлөөг тооцох

- а. Монгол Улсын ДНБ болон ДНБ-ий өсөлтөд Эрдэнэт үйлдвэрийн оруулж буй хувь нэмрийг тооцох (шууд, шууд бус болон дам нөлөөллийг тооцох), Эрдэнэт үйлдвэрийн ДНБ-д үзүүлж буй үржүүлэгч нөлөөг тооцох,
- б. Монгол Улсын ДНБ болон эдийн засгийн өсөлтийг Эрдэнэт үйлдвэрийн үр дүн орсноор болон ороогүй хувилбараар тооцож харьцуулах,
- б. Нэг хүнд ногдох ДНБ болон түүний өсөлтийг Эрдэнэт үйлдвэрийн үр дүн орсноор болон ороогүй хувилбараар тооцож харьцуулах,
- в. Монгол Улсын гадаад худалдаанд (экспорт, импорт) эзлэх хувь, гадаад валютын нөөц бүрдүүлэлтэд үзүүлж буй хувь нэмрийг тооцох,
- г. Монгол Улсын дотоодын нийт хөрөнгө оруулалтад Эрдэнэт үйлдвэрийн эзлэх хувийг тооцох, хөрөнгө оруулалтын үржүүлэгч нөлөөг тооцох (multiplier effect)
- д. Орон нутгийн ДНБ, эдийн засгийн өсөлт, дэд бүтцийн хөгжилд үзүүлсэн нөлөө, хувь нэмрийг тооцох
- е. Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд Эрдэнэт үйлдвэрийн үзүүлж буй хувь нэмрийг тооцох.

(2) Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогод Эрдэнэт үйлдвэрийн оруулж буй хувь нэмрийг тооцох:

- а. Эрдэнэт үйлдвэрийн улсын төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын хэмжээ, төсөвт эзлэх хувийг тооцох,
- б. Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын хэмжээ, орон нутгийн төсөвт эзлэх хувийг тооцох,
- в. Ижил төстэй ААН-үүдийн татварын орлого бүрдүүлэлтэй харьцуулсан судалгаа хийх.

(3) Эрдэнэт үйлдвэрийн нийгэмд оруулж буй хувь нэмэр, үр нөлөөг тооцох

- а. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтэд Эрдэнэт үйлдвэрийн ажиллах хүчний эзлэх хувь, Эрдэнэт үйлдвэрийн нөлөөгөөр бий болж буй шууд бус болон дам ажлын байрны тоог тооцох,
- б. Улсын хэмжээнд ажиллагчдын сарын бодит дундаж цалинд үзүүлж буй нөлөөллийг Эрдэнэт үйлдвэрийн оролцоотой, оролцоогүй хувилбараар тооцож харьцуулах,
- в. Өрхийн төсөвт (өрхийн сарын дундаж бодит мөнгөн орлого болон өрхийн бодит хэрэглээ, хадгаламжид) үзүүлж буй нөлөөллийг Эрдэнэт үйлдвэрийн оролцоотой, оролцоогүй хувилбараар тооцож харьцуулах,
- г. Үндэсний болон салбарын бүтээмж, тэдгээрийн өсөлтөд Эрдэнэт үйлдвэрийн оруулсан болон оруулж буй хувь нэмэр, нөлөөллийг тодорхойлох,
- д. Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төслүүд, түүний үр нөлөө, ижил төстэй ААН-үүдийн нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан зардалтай харьцуулсан судалгаа хийх,
- е. Бүс нутаг, орон нутагтай хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй нийгмийн төслүүд, тэдгээрийн үр нөлөөг тооцох

(4) Монгол Улсын эдийн засагт Эрдэнэт үйлдвэрийн цаашид үзүүлэх нөлөөг урьдчилан таамаглах

- а. Хөрөнгө оруулалтын төслүүдийг эрчимжүүлж, Үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулснаар Монгол Улсын ДНБ, түүний өсөлтөд Эрдэнэт үйлдвэрийн үзүүлэх нөлөөг 2030 он хүртэл урьдчилан таамаглах
- б. Монгол Улсын гадаад худалдаа болон улсын нэгдсэн төсөв, гадаад валютын нөөцөд оруулах хувь нэмрийг 2030 он хүртэл урьдчилан таамаглах

Даалгавар 3. Судалгааны нэгдсэн тайланг монгол, англи хэл дээр эцэслэн боловсруулж, хэвлэлтэд бэлэн болгох

Даалгавар 4. Захиалагч талын холбогдох мэргэжилтнүүдэд макро эдийн засгийн түвшинд судалгаа, шинжилгээ хийх онол, арга зүйн болон судалганы ажлын явц, үр дүнгийн талаар сургалт зохион байгуулах

Даалгавар 5. Судалгааны үр дүнгээр үйлдвэрийн газрын улс орны эдийн засаг, нийгэмд оруулж буй бодитой хувь нэмрийг таниулах эрдэм шинжилгээний хурлыг захиалагч талтай хамтран зохион байгуулах

4. Судалгааны ажлын тайлан бэлтгэх

Төсөл хэрэгжиж дууссаны дараа судалгааны ажлыг гүйцэтгэсэн байгууллага нь цуглуулсан баримт, нотолгоонд үндэслэсэн эцсийн тайланг англи болон монгол хэлээр хэвлэхэд бэлэн болгож, цахим болон цаасан хэлбэрээр төслийн захиалагчид хүлээлгэж өгнө. Судалгааны ажлын явцад хийгдэх тооцоолол, модель, (тооцооны загварын эх файл) үр дүн болон эцсийн тайланг ном хэлбэрээр 100 хувь хэвлэж захиалагчид хүлээлгэн өгнө.

5. Судалгааны ажлыг гүйцэтгэх хугацаа

Судалгааны ажлыг гэрээ байгуулснаас хойш 4 сарын хугацаанд буюу урьдчилсан байдлаар 2024.03.01-ээс 2024.07.01-ний хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөв. Ажил гүйцэтгэгчээс ажлын календарьчилсан төлөвлөгөөний саналыг ирүүлэх бөгөөд захиалагч талтай зөвшилцөн баталгаажуулна.

6. Судалгааны ажлын зохион байгуулалт, шаардагдах мэдээллээр хангах

Судалгааны ажлыг гүйцэтгэх явцад “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Захиргаа, удирдлага, санхүүгийн газар нь үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, үйлчилгээг гүйцэтгэгч байгууллагын зөвлөхүүдтэй хамтран ажиллах бөгөөд тус Газрын удирдлагын шийдвэрээр холбогдох ажилтнууд нь судалгааны ажилд шаардагдах өгөгдөл, мэдээллээр үйлчилгээг гүйцэтгэж буй байгууллагыг хангаж ажиллана. Мэдээллийн нууцлалтай холбоотой асуудлыг үйлчилгээний гэрээгээр зохицуулна.

7. Судалгааны ажлыг гүйцэтгэгчид тавих шаардлага

Судалгааны ажлыг гүйцэтгэх багт тавих ерөнхий шаардлага:

- Тус судалгааны ажлын чиглэлээр өмнө нь үйлчилгээний туршлагатай хуулийн этгээд байх;
- Макро эдийн засаг, санхүүгийн удирдлага, статистикийн чиглэлээр мэргэшсэн 4 ба түүнээс дээш тооны голлох мэргэжилтнээс бүрдсэн судалгааны баг ажиллах.

Судалгааны ажлыг гүйцэтгэх багийн голлох мэргэжилтнүүдэд тавих шаардлага:

Багийн ахлагч: - Эдийн засаг, бизнесийн удирдлагын салбарын зөвлөх

- Макро эдийн засаг болон салбар хоорондын судалгаа, макро, микро эдийн засгийн үзүүлэлтүүдэд тоон болон чанарын судалгаа хийж, харилцан хамаарлыг тодорхойлох чиглэлээр мэргэшсэн, эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр Докторын зэрэг хамгаалсан байх;
- Мэргэжлийн чиглэлээрээ 10-аас доогүй жил ажилласан байх;
- Макро эдийн засаг болон уул уурхайн салбарын эдийн засгийн чиглэлээр судалгаа, шинжилгээний болон бодлогын баримт бичиг боловсруулах, зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай байх;
- Судалгааны ажлын сэдвийн хүрээнд гадаад улс болон олон улсын байгууллагатай хамтран ажиллаж байсан бол давуу тал болно.

Багийн голлох 3 мэргэжилтэн: - Статистик, санхүү, эдийн засаг, мэдээллийн технологийн чиглэлийн зөвлөх

- Эдийн засгийн салбар хоорондын судалгаа, макро, микро түвшний үзүүлэлтүүдэд тоон болон чанарын судалгаа хийж, харилцан хамаарлыг тодорхойлох чиглэлээр мэргэшсэн, статистик, эдийн засаг, бизнесийн удирдлага, мэдээллийн технологи, дата боловсруулалтын чиглэлээр магистраас дээш зэрэг, цолтой байх;
- Мэргэжлийн чиглэлээрээ 8-аас доошгүй жил ажилласан байх;
- Макро эдийн засаг болон уул уурхайн салбарын эдийн засгийн чиглэлээр судалгаа, шинжилгээний болон бодлогын баримт бичиг боловсруулах, зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Судалгааны ажлын сэдвийн хүрээнд гадаад улс болон олон улсын байгууллагатай хамтран ажиллаж байсан бол давуу тал болно.

Хянасан:

ТЭЗШХ-ийн дарга

ТЭЗШХ-ийн ТМА-ны дарга

Боловсруулсан:

ТЭЗШХ-ийн эдийн засагч

 /Р.Очбадрах/
 /Д.Будсүрэн/

 /Ц.Оюунболор/